



**/ЭШ-ний нийтлэлд тавигдах шаардлага/
ӨГҮҮЛЭЛ ХҮЛЭЭН АВАХАД ТАВИГДАХ ШААРДЛАГА**

ЗОРИЛГО: Дэлхийн магадлан итгэмжлэлийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх хүрээнд олон нийтэд чанарын баталгаажуулалт, магадлан итгэмжлэлийн ач холбогдлыг сурталчлан таниулах, суралцахуйн үр дүнг хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээтэй уялдуулах, мэргэжилтнүүдийн ур чадварын шилжилтийг дэмжих, боловсрол ба ажиллах хүчний чанар, уялдааг бэхжүүлэхэд оршино.

ХАМРАХ ХҮРЭЭ: Ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим, ажил олгогч, сургалтын байгууллага, мэргэжлийн зөвлөл, холбоод

СЭДЭВ: “СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН-ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ”

Боловсролын магадлан итгэмжлэл сэтгүүлд зориулсан

I. Ерөнхий шаардлага

- Зохиогчийн эрх зөрчөөгүй байна.
- А4 хэмжээтэй 8-10 хүртэлх хуудсанд багтсан байна.
- Өгүүлэл нь **АРА 7** ишлэл зүй, баримтжуулалтын загварын дагуу бичигдсэн байна.
- Өгүүллийн нийт хэмжээ нь 3000–5000 үг (ном зүй, зураг, хүснэгт, хавсралт орсон) байна.

Монгол болон англи хэл дээр бичих боломжтой.

- Өгүүллийг **Microsoft Word (.doc/.docx)** файл хэлбэрээр илгээнэ.
- Шинжлэх ухааны хэл найруулгыг баримтална

II. Өгүүллийн бүтэц

1. Нүүр хуудас (танилцуулга):

- Өгүүллийн гарчиг
- Зохиогч бүрийн овог, нэр, эрдмийн зэрэг, албан тушаал, харьяалах байгууллагын нэр
- Холбоо барих зохиогчийн нэр, цахим хаяг (email)

2. Хураангуй:

- 200 үгнээс хэтрэхгүй
- Монгол болон англи хэлээр
- Судалгааны зорилго, арга зүй, гол үр дүн, дүгнэлт туссан байна.

3. Түлхүүр үгс:

- 5–6 үг, англи ба монголоор
- Таслалаар тусгаарласан байна.

4. Үндсэн бүтэц:

- Удиртгал
 - Судлагдсан байдлын тойм
 - Арга зүй
 - Үр дүн
 - Хэлэлцүүлэг ба дүгнэлт
5. **Талархал (шаардлагатай бол)**
6. **Санхүүжилтийн талаарх мэдээлэл (байгаа тохиолдолд):**
- Санхүүжүүлэгч байгууллага, тэтгэлгийн дугаар
7. **Ном зүй:**
- АРА 7 хэв маягийн дагуу бүрэн бичигдсэн байна.
 - Эш татсан
 - бүх эх сурвалжийг жагсаана.
8. **Хавсралт (шаардлагатай бол)**
- Асуулгын хуудас, нэмэлт материал
9. **Хүснэгт, зураг:**
- Хүснэгт, зураг бүрийг дугаарлаж, тайлбартай оруулна.
 - Зураг нь өндөр нягтаршилтай (300 dpi-аас доошгүй) байна.
10. **Зохиогчийн товч танилцуулга:**
- Зохиогч тус бүрийн 150–200 үгэнд багтаасан намтар
 - Боловсрол, мэргэшил, судалгааны чиглэл, харьяа байгууллагын мэдээлэл багтсан байна.

III. Бичвэрийн техник шаардлага

- **Хуудасны тохиргоо:**
 - А4 хэмжээтэй, дээд/доод/баруун/зүүн зайнууд 2.5 см
 - Мөр хоорондын зай: 1.5
 - Үсгийн фонт: **Times New Roman**, үсгийн хэмжээ: 12 pt
 - Эгцэлсэн (Justify) бичвэр
 - Хуудасны дугаар баруун доод буланд
- **Гарчиг, дэд гарчиг:**
 - Гарчиг – 14 pt, **bold**
 - Дэд гарчиг – шаталсан дугаарлалттай (Жишээ: 1.1, 1.2), **bold**
- **Нэр томьёо ба товчлол:**
 - Эхний удаа бүтнээр бичиж, хаалтанд товчлоно
(Жишээ: Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөл (БМИҮЗ))
- **Ишлэл, эш таталт:**
 - Бүх эшлэл АРА 7 загвараар бичигдсэн байна
 - Эшлэл бүхий өгүүлбэр бүрт зохих эх сурвалж тэмдэглэгдсэн байна

АРА 7 СТАНДАРТЫН ЗАГВАРААР ИШЛЭЛ ЗҮЙ, ЭХ СУРВАЛЖИЙГ ТЭМДЭГЛЭХ ЗАГВАРЫГ ЖИШЭЭГЭЭР ХАРУУЛАВ.

1. Монгол ном:

Батсүх, Ж. (2021). *Мэргэжлийн боловсролын хөгжил ба чанарын үнэлгээ*. Адмон ХХК.

2. Сэтгүүлд хэвлэгдсэн өгүүлэл:

Дорж, Д., & Сүхбат, Н. (2019). Мэргэжлийн боловсролын сургалтын чанар ба үнэлгээний асуудал. *Боловсрол судлалын сэтгүүл*, 15(1), 45–58.

3. Гарын авлага / тайлан / баримт бичиг (байгууллага зохиогчтой):

Боловсрол, шинжлэх ухааны яам. (2022). *Мэргэжлийн боловсрол, сургалтын чанарын баталгаажуулалтын журам*. https://moe.gov.mn/documents/TVET_quality_guide.pdf

4. Судалгааны тайлан (байгууллага):

Мэргэжлийн боловсрол, сургалтын хөгжлийн үндэсний төв. (2020). *Сургалтын байгууллагын дотоод үнэлгээний аргачлал*. Нийслэлийн хэвлэл.

5. Диссертаци / төгсөлтийн ажил:

Түмэннаст, Б. (2018). *Мэргэжлийн боловсролын чанарын үнэлгээний загварчлал* [Докторын диссертаци, МУБИС]. Монгол Улсын Их Сургууль номын сан.

6. Вэб эх сурвалж:

Боловсролын магадлан итгэмжлэлийн зөвлөл. (2023). *Чанарын баталгаажуулалт ба магадлан итгэмжлэлийн тогтолцоо*. https://mncea.edu.mn/info/quality_assurance